



**НИЙСЛЭЛИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Жанжин Д.Сүхбаатарын талбай 7, 1 дүгээр хороо,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0035  
Утас/Факс: (976-11) 32-71-99,  
<http://www.ulaanbaatar.mn>

2020 04 10 № 03/1707  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН  
ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДАД**

Нийслэлийн Онцгой комиссын 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 09 дүгээр хурлын тэмдэглэлийг хүргүүлэв.

Коронавируст /КОВИД-19/ халдвараас сэргийлэх талаар Засгийн газар, Улс, нийслэлийн Онцгой комиссоос авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг эрчимжүүлж, хэрэгжилтийг бүрэн хангуулж ажиллахыг мэдэгдье.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР: ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Р.БАТРАГЧАА



111820001236



## НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 04 сарын 09 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Нийслэлийн Онцгой комиссын 09 дүгээр хурал 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 16:00 цагт цахимаар гишүүдийн 94.5 хувийн ирцтэй хуралдав.

### ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Коронавируст /КОВИД-19/ халдварын нөхцөл байдлын мэдээллийг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга танилцуулж, халдвараас сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа ажлыг эрчимжүүлж ажиллах талаар Онцгой комиссын дарга үүрэг чиглэл өгөв.

### ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

#### Нэг. Нутгийн захиргааны байгууллагуудад

1.1. Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/168 дугаар захирамжийн хэрэгжилтийн хүрээнд нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, ил задгай газарт нус шүлсээ хаях, бие засах, хог хаяж орчныг бохирдуулах зэрэгт хяналт тавьж ажиллаж байгаа алба хаагчдын ажлыг эрчимжүүлж гүйцэтгэлийг хянах, нэгдсэн дүн мэдээг өдөр бүр шуурхай штабт өгч ажиллах.

1.2. Орон сууц, гэр хорооллын гудамж талбайд хүүхдүүд олноор цугларч, тоглож байгаад хяналт тавьж, зөвлөмж, сэрэмжлүүлэг хүргэж ажиллах.

#### Хоёр. Дүүргийн Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт

2.1. Гадаадын улс орнуудаас ирж 21 хоног тусгаарлагдсан иргэд тусгаарлалтын хугацаа дуусаж гэртээ 14 хоног тусгаарлалтад байх хугацаанд Онцгой комиссын орлогч даргын баталсан “Гэрийн тусгаарлалтад байгаа иргэдийн хяналтыг зохицуулах түр заавар”-ыг мөрдүүлж иргэнийг орж гаргуулахгүй байхад бүрэн хяналт тавьж, Эрүүл мэнд, Цагдаа, Мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах.

2.2. Хотын соёлыг бий болгох, иргэдийн үүрэг хариуцлага ухамсрыг дээшлүүлэх, коронавируст /КОВИД-19/ халдвараас сэргийлж хороодын олон нийтийн байцаагчийн эрхтэй албан хаагчдыг 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс эхэлж хотын эргүүлээр ажиллуулах.

#### Гурав. Нийслэлийн Мэдээлэл технологийн газар, Нийслэлийн Цагдаагийн удирдах газарт

Гэрийн тусгаарлалтад 14 хоног байх иргэдийн мэдээллийг Улс, нийслэлийн Онцгой комиссын шуурхай штабын мэдээллийн санд оруулах, орж гарах хөдөлгөөнийг цахимаар хянах нөхцөлийг судалж 4 дүгээр сарын 15-ны өдрийн дотор танилцуулах.

Дөрөв. Нийслэлийн Онцгой байдлын газар,  
Нийслэлийн Эрүүл мэндийн газар,  
Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар,  
Нийслэлийн Цагдаагийн удирдах газарт

Коронавируст /КОВИД-19/ халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний төлөвлөгөөг 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор боловсруулж батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллах.

Тав. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын  
Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтэс,  
Нийслэлийн Онцгой байдлын газар,  
Нийслэлийн Цагдаагийн удирдах газар,  
Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар,  
Тээврийн Цагдаагийн албаны Замын цагдаагийн газарт

Коронавируст /КОВИД-19/ халдвараас сэргийлэх талаар болон иргэд амны хаалтаа тогтмол зүүж хэвших, гарын ариун цэвэр сахих, онцын шаардлагагүй бол гадуур явахгүй байх уриалга сэрэмжлүүлгийг хэвлэл мэдээлэл, чанга яригчтай автомашин, тусгай техник хэрэгслээр олон удаагийн давтамжтай сэрэмжлүүлж уриалах.

Зургаа. Нийслэлийн Боловсролын газарт

Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа 09 дүгээр сарын 01 хүртэл хаахтай холбогдуулан төгсөх ангийн улсын шалгалт, мөн их дээд сургуулийн төгсөлтийн шалгалтын үйл ажиллагааг хүн олноор цуглуулахгүй, эрүүл мэндийн зөвлөмж зааврын хүрээнд цахимаар зохион байгуулах.

Долоо. Нийслэлийн Аялал жуулчлалын газар,  
Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газарт

Сувиллын газруудын үйл ажиллагаанд тавих хяналтыг эрчимжүүлж, хүн олноор авахгүй байх, эрүүл ахуйн стандарт, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлж шаардлага хангахгүй сувиллын газрын үйл ажиллагааг зогсоох.

Найм. Нийслэлийн Цагдаагийн удирдах газарт

Улсын Онцгой комиссын Шуурхай штабаас ирүүлсэн үүргийн хэрэгжилтийг хангаж Улаанбаатар хотын Гүний гаалийн хяналтын талбайд ачаа тээвэр хүргэж ирсэн гадаадын жолооч, ачаа буулгагч нарт тавих хяналтыг өндөржүүлэх.

Ес. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар,  
Нийслэлийн Аялал жуулчлалын газар,  
Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар,  
Нийслэлийн Цагдаагийн удирдах газарт

Коронавируст /КОВИД-19/ халдвараас сэргийлэх ажлын хүрээнд үйл ажиллагааг нь зогсоосон худалдаа үйлчилгээ, амралтын газруудаас эрүүл ахуйн шаардлага хангасан зарим аж ахуй нэгжийн үйл ажиллагааг нээх асуудлыг судалж 2020 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн дотор танилцуулах.

Арван. Нийслэлийн Байгаль орчны газар,  
Нийслэлийн Онцгой байдлын газар,  
Нийслэлийн Цагдаагийн удирдах газар,  
Тээврийн Цагдаагийн албаны Замын цагдаагийн газарт

10.1. Хаврын хуурайшилтын улиралд ногоон бүсэд ой хээрийн түймэр гарахаас, зуслангийн айл өрхүүд хашааны өнжмөл өвсөө шатаахаас урьдчилан сэргийлж, байгаль хамгаалагч нарын ажлыг эрчимжүүлэн эргүүл хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж ажиллах.

10.2. Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/487 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангуулж хөдөлгөөнт эргүүл ажиллуулан ой хээр, өнжмөл шар өвсний түймэр гарах эрсдэлээс сэргийлж нийслэлийн ногоон бүсэд ойн дагалт баялгийг ашиглах, аялал зугаалга, ууланд алхах, ил задгай гал түлэхийг зогсоох.

ДАРГА



С.АМАРСАЙХАН